ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/02/НА-СТА-ТЕЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Монгол Улсын Ерөнхий аудиторын<br>Орлогч: Я.Самбууням<br>Утас: 51-261885<br>Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn<br>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Э.Энхбаатар<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ<br>Утас: 261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn<br>Аудитор: П.Ариунзаяа<br>Утас: 261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2025.04.25 № 1612

танай ______________-ны № ______________-т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
Ж.ЭНХБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааварын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй 253,154.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Сангийн яам Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны хооронд байгуулсан "Хөдөө Аж Ахуйн бага оврын трактор худалдан авах", "Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний үндсэн зээлийн 98,398.8 сая төгрөгийн, хүүгийн төлбөрийн 18,280.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэлтэй;
- "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах" ӨТБГ-23/01 дугаартай санхүүгийн түрээсийн гэрээний 29,489.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэлтэй;

- "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-ийн дамжуулан зээлийн гэрээний 2024 онд төлөх үндсэн зээлийн 7,234.9 сая төгрөг, хүүгийн 3,798.3 сая төгрөгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй;
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох санхүүжилтийн дүнгээс 11,393.5 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн;
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 134 зээлдэгчийн 19,442.0 сая төгрөгийн шууд зээлийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Биобэлдмэл худалдах, худалдан авах нэмэлт гэрээг байгуулж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 1,619.0 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн нь төсвийг төсвийн жил дамжуулан зарцуулах, гэрээнд заасан хугацаанд үүргийн биелэлт хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн;

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 41.2.3, 41.2.7, 43 дугаар зүйлийн 43.5, 45 дугаар зүйлийн 45.2, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Өрийн удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 48 дугаар зүйлийн 48.2 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд Санхүүгийн тайлангийн Нийцсэн бөгөөд зохистой, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх болон хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/96 дугаар тушаалаар “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг баталсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны нийт зарлага ба цэвэр зээлд 716,016.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсний 95.7 хувь буюу 685,562.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 321,844.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн Газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Төвийн бүсийг "Хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс" болгон төрөлжүүлэн хөгжүүлэх, “Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх” бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэхээр тусгасан.

Мөн Засгийн Газрын 2024 оны 38 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулан, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”-ээр тогтоосон байна. Уг тогтоолтой холбогдуулан Засгийн газрын 2024 оны 32 дугаар хуралдааны тэмдэглэлээр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн, үйлдвэрийн яам болон харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг гаргасны дагуу “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг дунд үйлдвэрийн

газар, Хөдөө аж ахуйн "Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК, Зээлийн батлан даалтын сангийн Төвийн бүсийн салбар зэрэг байгууллагууд Дархан-Уул аймагт нүүн байрших ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн цаглабарт хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг хэрэгжүүлж аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт 14 цахим сайт, аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын 42, нийт 56 цахим сайт, 37 мэдээллийн дэд системийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАГДЖАВ

## 2. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/ мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,065,133,480.3** | **1,185,214,241.5** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 251,388,379.3 | 329,154,084.2 |
| 33 | АВЛАГА | 649,642,086.9 | 588,701,360.0 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 7,161,395.7 | 7,170,514.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 66,585,947.3 | 85,442,041.5 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 60,266,861.2 | 101,355,462.8 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 30,088,809.9 | 73,390,779.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **236,613,929.6** | **254,888,656.5** |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 40,000,000.0 | 35,000,000.0 |
| 37300 | Урт хугацаат зээл | 40,000,000.0 | 35,000,000.0 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 196,613,929.6 | 219,888,656.5 |
| 39200 | Биет хөрөнгө | 148,489,278.0 | 171,101,041.1 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 48,124,651.6 | 48,787,615.3 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,301,747,409.9** | **1,440,102,898.0** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **769,507,023.0** | **788,793,865.4** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 115,599,983.1 | 131,742,291.4 |
| 41200 | Богино хугацаат зээлийн өглөг | 463,334.6 | 440,334.6 |
| 41300 | Өглөг | 114,165,123.4 | 123,075,830.5 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 971,525.2 | 8,226,126.4 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 653,907,039.9 | 657,051,574.0 |
| 42200 | Урт хугацаат зээл | 653,907,039.9 | 657,051,574.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **532,240,386.9** | **651,309,032.6** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 532,240,386.9 | 651,309,032.6 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 206,842,115.4 | 137,931,064.7 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 11,963,789.0 | 93,094,010.1 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 10.0 | 10.0 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 274,617,232.9 | 381,647,269.8 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 38,817,239.6 | 38,636,677.9 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0 | 0 |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | 0 | 0 |
| 51600 | Нөөцийн сан | 0 | 0 |
| 52 | Хяналтын бус хувь оролцоо | 0 | 0 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,301,747,409.9** | **1,440,102,898.0** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/ мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **490,305,870.8** | **785,896,451.1** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 103,208,197.7 | 126,728,990.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 103,208,197.7 | 126,728,990.3 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 387,097,673.1 | 659,167,460.8 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **388,990,836.6** | **596,033,515.0** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 388,990,836.6 | 596,033,515.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 199,100,057.2 | 257,107,267.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 41,552,330.2 | 55,922,462.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,315,514.5 | 7,030,891.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,038,700.8 | 2,241,695.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,126,129.0 | 3,589,073.7 |
| 2105 | Нормативт зардал | 27,900,177.2 | 28,867,832.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,168,374.1 | 1,256,931.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,753,770.4 | 3,049,317.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 97,936,451.8 | 126,356,666.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,308,609.2 | 28,792,397.6 |
| 211 | ХҮҮ | 7,148,392.9 | 6,972,290.9 |
| 212 | ТАТААС | 117,229,396.8 | 316,102,728.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 65,512,989.6 | 15,851,228.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0 | 0 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **101,315,034.2** | **189,862,936.1** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **18,434,754.4** | **34,583,427.4** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **58,928,187.6** | **101,485,135.4** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **60,821,600.9** | **122,961,228.1** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/ мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **984,629,022.6** | **1,166,754,712.8** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 559,168,177.3 | 482,849,757.1 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 559,168,177.3 | 482,849,757.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 425,460,845.3 | 683,904,955.6 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **821,076,177.7** | **882,495,184.4** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 821,076,177.7 | 882,495,184.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 620,221,165.4 | 545,218,830.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 44,719,267.5 | 64,248,108.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,734,147.5 | 9,133,723.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,819,059.1 | 3,983,712.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,864,390.5 | 53,486,174.2 |
| 2105 | Нормативт зардал | 28,223,858.2 | 29,777,468.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,722,067.6 | 8,471,297.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,775,857.4 | 3,051,156.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 520,358,163.6 | 337,236,129.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,004,354.0 | 35,831,060.1 |
| 211 | ХҮҮ | 4,944,217.4 | 6,972,290.9 |
| 212 | ТАТААС | 112,229,396.8 | 311,102,728.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 83,681,398.1 | 19,201,334.4 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **163,552,844.8** | **284,259,528.4** |
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **4,909,543.3** | **4,499,607.3** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **75,421,630.9** | **117,152,202.0** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 75,421,630.9 | 117,152,202.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 75,421,630.9 | 117,152,202.0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(70,512,087.6)** | **(112,652,594.7)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(62,668,429.1)** | **(93,841,228.8)** |
| 14 | Бусад эх үүсвэр | 43,185.5 | 3,502,352.2 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 43,303,396.2 | 69,836,062.8 |
| 24 | ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР | 13,872,903.7 | 14,702,785.5 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 5,535,314.8 | 12,804,732.8 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **30,372,328.1** | **77,765,704.9** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 221,016,051.2 | 251,388,379.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 251,388,379.3 | 329,154,084.2 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/ мянган төгрөгөөр /*

| Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **446,085,903.0** | **0.0** | **446,085,903.0** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 25,619,788.1 | 0.0 | 25,619,788.1 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 471,705,691.1 | 0.0 | 471,705,691.1 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (11,985.7) | 0.0 | (11,985.7) |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 232,976.9 | 0.0 | 232,976.9 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| Өмчид гарсан өөрчилөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| Зарласан ногдол ашиг | (507,896.4) | 0.0 | (507,896.4) |
| Тайлант үеийн үр дүн | 60,821,600.9 | 0.0 | 60,821,600.9 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **532,240,386.9** | **0.0** | **532,240,386.9** |
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **532,240,386.9** | **0.0** | **532,240,386.9** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 423,416.2 | 0.0 | 423,416.2 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 532,663,803.1 | 0.0 | 532,663,803.1 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (180,561.7) | 0.0 | (180,561.7) |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 605,170.5 | 0.0 | 605,170.5 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| Өмчид гарсан өөрчилөлт | (4,740,607.4) | 0.0 | (4,740,607.4) |
| Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тайлант үеийн үр дүн | 122,961,228.1 | 0.0 | 122,961,228.1 |
| **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **651,309,032.6** | **0.0** | **651,309,032.6** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **716,016,582,400.00** | **685,562,203,145.02** | **30,454,379,254.98** | **95.7** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **555,484,204,900.00** | **531,222,151,774.73** | **24,262,053,125.27** | **95.6** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **213,014,109,300.00** | **205,435,128,288.62** | **7,578,981,011.38** | **96.4** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 53,688,088,700.00 | 51,513,734,587.58 | 2,174,354,112.42 | 96.0 |
| Үндсэн цалин | 31,115,489,800.00 | 29,989,676,057.51 | 1,125,813,742.49 | 96.4 |
| Нэмэгдэл | 14,579,370,000.00 | 13,942,443,096.09 | 636,926,903.91 | 95.6 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 4,333,574,700.00 | 4,251,127,960.38 | 82,446,739.62 | 98.1 |
| Урамшуулал | 3,659,654,200.00 | 3,330,487,473.60 | 329,166,726.40 | 91.0 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **6,812,604,800.00** | **6,467,415,938.99** | **345,188,861.01** | **94.9** |
| Тэтгэврийн даатгал | 4,639,701,000.00 | 4,425,401,713.48 | 214,299,286.52 | 95.4 |
| Тэтгэмжийн даатгал | 541,349,400.00 | 514,102,944.14 | 27,246,455.86 | 95.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 280,132,900.00 | 292,082,681.54 | (11,949,781.54) | 104.3 |
| Ажилгүйдлийн даатгал | 270,969,800.00 | 248,144,284.16 | 22,825,515.84 | 91.6 |
| Эрүүл мэндийн даатгал | 1,080,451,700.00 | 987,684,315.67 | 92,767,384.33 | 91.4 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **2,427,927,300.00** | **2,290,161,575.92** | **137,765,724.08** | **94.3** |
| Гэрэл, цахилгаан | 552,505,800.00 | 490,376,271.49 | 62,129,528.51 | 88.8 |
| Түлш, халаалт | 1,385,723,500.00 | 1,333,208,895.48 | 52,514,604.52 | 96.2 |
| Цэвэр, бохир ус | 133,259,000.00 | 120,554,680.55 | 12,704,319.45 | 90.5 |
| Байрны түрээс | 356,439,000.00 | 346,021,728.40 | 10,417,271.60 | 97.1 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **1,793,791,000.00** | **1,754,970,817.38** | **38,820,182.62** | **97.8** |
| Бичиг хэрэг | 301,855,200.00 | 301,507,694.84 | 347,505.16 | 99.9 |
| Тээвэр, шатахуун | 934,968,400.00 | 912,737,819.30 | 22,230,580.70 | 97.6 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 218,228,100.00 | 204,769,038.24 | 13,459,061.76 | 93.8 |
| Ном, хэвлэл | 440,000.00 | 440,000.00 | 0.00 | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,890,400.00 | 8,100,492.00 | 789,908.00 | 91.1 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 329,408,900.00 | 327,415,773.00 | 1,993,127.00 | 99.4 |
| **Нормативт зардал** | **26,458,095,000.00** | **25,802,759,726.73** | **655,335,273.27** | **97.5** |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 26,398,220,100.00 | 25,736,505,647.73 | 661,714,452.27 | 97.5 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 59,874,900.00 | 66,254,079.00 | (6,379,179.00) | 110.7 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,640,056,400.00** | **9,548,692,150.58** | **91,364,249.42** | **99.1** |
| Багаж, техник, хэрэгсэл | 8,238,308,100.00 | 8,203,454,649.40 | 34,853,450.60 | 99.6 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 47,615,000.00 | 46,971,248.00 | 643,752.00 | 98.6 |
| Урсгал засвар | 1,354,133,300.00 | 1,298,266,253.18 | 55,867,046.82 | 95.9 |
| **Томилолт, зочны зардал** | **2,189,521,100.00** | **2,087,976,068.00** | **101,545,032.00** | **95.4** |
| Дотоод албан томилолт | 2,189,521,100.00 | 2,087,976,068.00 | 101,545,032.00 | 95.4 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **100,605,914,500.00** | **96,734,290,055.56** | **3,871,624,444.44** | **96.2** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 99,831,026,500.00 | 96,007,221,768.49 | 3,823,804,731.51 | 96.2 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 47,991,200.00 | 44,993,500.00 | 2,997,700.00 | 93.8 |
| Даатгалын үйлчилгээ | 58,879,800.00 | 50,552,331.07 | 8,327,468.93 | 85.9 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 28,169,700.00 | 20,753,902.00 | 7,415,798.00 | 73.7 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 7,509,900.00 | 4,536,700.00 | 2,973,200.00 | 60.4 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 589,538,800.00 | 569,667,670.00 | 19,871,130.00 | 96.6 |
| Газрын төлбөр | 42,798,600.00 | 36,564,184.00 | 6,234,416.00 | 85.4 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,398,110,500.00** | **9,235,127,367.88** | **162,983,132.12** | **98.3** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 9,287,523,600.00 | 9,157,159,935.48 | 130,363,664.52 | 98.6 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 110,586,900.00 | 77,967,432.40 | 32,619,467.60 | 70.5 |
| **ТАТААС** | **332,099,648,500.00** | **316,102,728,220.17** | **15,996,920,279.83** | **95.2** |
| **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | **332,099,648,500.00** | **316,102,728,220.17** | **15,996,920,279.83** | **95.2** |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 332,099,648,500.00 | 316,102,728,220.17 | 15,996,920,279.83 | 95.2 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,370,447,100.00** | **9,684,295,265.94** | **686,151,834.06** | **93.4** |
| **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **687,871,200.00** | **611,837,228.96** | **76,033,971.04** | **88.9** |
| Засгийн газрын гадаад шилжүүлэг | 687,871,200.00 | 611,837,228.96 | 76,033,971.04 | 88.9 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **9,682,575,900.00** | **9,072,458,036.98** | **610,117,863.02** | **93.7** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 321,288,200.00 | 291,796,290.00 | 29,491,910.00 | 90.8 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,124,485,000.00 | 2,916,984,103.00 | 207,500,897.00 | 93.4 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,480,433,700.00 | 1,258,090,480.68 | 222,343,219.32 | 85.0 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,420,549,500.00 | 4,281,388,937.30 | 139,160,562.70 | 96.9 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 335,819,500.00 | 324,198,226.00 | 11,621,274.00 | 96.5 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **120,533,764,200.00** | **105,197,248,156.11** | **15,336,516,043.89** | **87.3** |
| Барилга байгууламж | 49,130,524,200.00 | 41,927,404,344.96 | 7,203,119,855.04 | 85.3 |
| Их засвар | 2,000,000,000.00 | 1,813,663,183.65 | 186,336,816.35 | 90.7 |
| Тоног төхөөрөмж | 69,403,240,000.00 | 61,456,180,627.50 | 7,947,059,372.50 | 88.5 |
| **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **39,998,613,300.00** | **49,142,803,214.18** | **(9,144,189,914.18)** | **122.9** |
| Эргэж төлөгдөх зээл | 39,998,613,300.00 | 49,142,803,214.18 | (9,144,189,914.18) | 122.9 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **716,016,582,400.00** | **700,225,660,786.64** | **15,790,921,613.36** | **97.8** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **671,267,502,300.00** | **632,899,839,815.63** | **38,367,662,484.37** | **94.3** |
| Улсын төсвөөс санхүүжих | 671,267,502,300.00 | 632,899,839,815.63 | 38,367,662,484.37 | 94.3 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **54,588,466,800.00** | **57,880,674,507.92** | **(3,292,207,707.92)** | **106.0** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 54,366,935,100.00 | 57,401,609,995.38 | (3,034,674,895.38) | 105.6 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 221,531,700.00 | 479,064,512.54 | (257,532,812.54) | 216.3 |
| **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | **(9,839,386,700.00)** | **9,445,146,463.09** | **(19,284,533,163.09)** | **(96.0)** |
| Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | (9,839,386,700.00) | 9,445,146,463.09 | (9,284,533,163.09) | (96.0) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 12,357,782,158.70 | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 27,021,239,800.32 | | |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **4,239** | **3,947** | 292 | 93.1 |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **51** | **51** | 0 | 100.0 |
| Төсвийн байгууллага | 51 | 51 | 0 | 100.0 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **2,094** | **1,948** | 146 | 93.0 |
| Удирдах ажилтан | 68 | 67 | 1 | 98.5 |
| Гүйцэтгэх ажилтан | 1,864 | 1,721 | 143 | 92.3 |
| Үйлчлэх ажилтан | 162 | 160 | 2 | 98.8 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **2,094** | **1,948** | 146 | 93.0 |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1,438 | 1,292 | 146 | 89.8 |
| ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | 12 | 12 | 0 | 100.0 |
| Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 | 0 | 100.0 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 641 | 641 | 0 | 100.0 |
| Улс төрийн албан хаагч (УТ) | 2 | 2 | 0 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **50,224,241,675.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **50,214,241,675.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **48,301,378,996.44** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **2,140,786,094.89** |
| 210101 | Үндсэн цалин | | 257,144,242.03 |
| 210102 | Нэмэгдэл | | 1,586,999,474.74 |
| 210104 | Урамшуулал | | 270,136,045.12 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 26,506,333.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **273,413,313.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 203,250,741.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 24,509,606.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 12,820,658.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 7,312,679.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 25,519,628.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **30,619,565.30** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 88,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 9,101,565.30 |
| 210304 | Байрны түрээс | | 21,430,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **584,714,965.86** |
| 210401 | Бичиг хэрэг | | 29,224,414.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 494,008,109.86 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,308,372.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 20,987,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 3,030,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 36,157,070.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **4,027,288,368.60** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 3,969,016,408.60 |
| 210502 | Хоол, хүнс | | 20,624,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 37,647,460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **241,969,954.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 126,768,950.00 |
| 210602 | Тавилга | | 11,467,690.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 50,840,900.00 |
| 210604 | Урсгал засвар | | 52,892,414.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **806,555,240.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | 6,800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 799,755,240.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **38,441,867,724.82** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 38,441,867,724.82 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **1,754,163,769.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,741,192,769.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 12,971,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **1,912,862,678.82** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **160,936,088.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | | 2,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 158,936,088.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **1,751,926,590.82** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,746,373,340.89 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 5,553,249.93 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **10,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **10,000,000.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | | 10,000,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **50,430,591,564.76** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **50,430,591,564.76** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 297,428,072.21 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 15,887,504,070.55 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 31,530,092,266.95 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,715,567,155.05 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **0** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 291,051,543.63 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 457,772,796.73 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 147,577.9 сая төгрөгийн 68 алдаа илэрснээс аудитын явцад 147,563.8 сая төгрөгийн 64 алдааг залруулж, 14,157.8 сая төгрөгийн 4 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Аудитаар нийт 253,140.0 сая төгрөгийн 229 зөрчил[1] илэрснээс, 181.6 сая төгрөгийн зөрчилд 38 төлбөрийн акт тогтоож, 230,791.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 92 албан шаардлага хүргүүлж, 22,167.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 98 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 253,140.0 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 6,718.9 сая төгрөгөөс өндөр тул “**Хязгаарлалттай”** дүгнэлт өгөв.

### 3.1 Харьяа байгууллагууд

ТЕЗ-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 64 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 52 байгууллагад дүгнэлт гаргаж / *Өөрчлөлтгүй 38, Хязгаарлалттай 12, Сөрөг 2* / 12 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж аудитыг гүйцэтгэсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 147,577.9 сая төгрөгийн 68 алдаа илэрснээс аудитын явцад 147,563.8 сая төгрөгийн 64 алдааг залруулж, 14.2 сая төгрөгийн 4 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 172,452.2 сая төгрөгийн 225 зөрчил илрүүлснээс 181.6 сая төгрөгийн зөрчилд 38 төлбөрийн акт тогтоож, 150,103.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 90 албан шаардлага хүргүүлж, 22,167.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 96 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 80,687.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

#### 3.2.1 Албан шаардлага

1. “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК санхүүгийн тайланд Хөдөө аж ахуйн бага оврын трактор, жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөрийн хүрээнд дамжуулан зээлийн болон бусад үндсэн дэмжлэгтэй холбоотой үүссэн ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний 19 байгууллагад хамаарах 4,487.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй боловч үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, ..." 20.2.6-д “эд хөрөнгийн болон

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгээгүй 4,487.9 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо, нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд бүртгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хооронд 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр "Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах", Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн хүрээнд байгуулсан дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээний хүрээнд талууд 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг байгуулж, үлдэгдлийг төгрөгт шилжүүлэн, зээлийн жилийн хүүг 6 хувь байхаар, зээлийн эргэн төлөлтийн хуваарьт сүүлийн төлөлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байхаар заасан боловч 2024 оны жилийн эцэст үндсэн зээлийн 98,398.8 сая төгрөгийн, хүүгийн 18,280.5 сая төгрөгийн хугацаа хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүнээс Засгийн газрын 2017 оны "Агаарын хэт халалт, хуурайшилттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай" 205 дугаар тогтоол, 2020 оны "Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 138 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор Онцгой байдлын ерөнхий газарт үнэ төлбөргүй шилжүүлсэн, газар тариалан эрхлэгчдэд хөдөө аж ахуйн, техник тоног төхөөрөмжийг үнийг 50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр борлуулснаас үнийн зөрүүний алдагдал нэмэгдсэн, дамжуулан зээлийн гэрээг ам.доллароор, борлуулалтын гэрээг төгрөгөөр байгуулснаас голлон нөлөөлж жил бүр их хэмжээний ханшийн зөрүү нэмэгдсэн зэрэг салбарт төрөөс баримталсан бодлоготой холбоотой 76,199.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах талаар Төсвийн ерөнхийлөн захирагч буюу дэд зээлдэгчийн зүгээс бодлогын үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, эцсийн зээлдэгчийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналт сул байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т " өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"", Өрийн удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Дэд болон эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэгтэй", 32.2-т "Тухайн салбарт төрөөс баримталж байгаа бодлого, зохицуулалтаас шалтгаалж дамжуулан зээлдүүлсэн зээл төлөгдөхгүй байх эрсдэл үүссэн тохиолдолд тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ тухай мэдэгдлийг нотлох баримт, тооцоо, судалгааны хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал, дүгнэлт гаргуулахаар нэн даруй хүргүүлнэ", Засгийн газрын 2021 оны 211 дүгээр тогтоолоор баталсан " Засгийн Газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам"-ын 4.1-д "Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний оролцогч талууд Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан үүргийг хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналт сул, гэрээний үүрэг хангагдаагүй, хугацаа хэтэрсэн хуримтлагдсан өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

### 3.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.Орлогын төлөвлөлттэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Улсын төсөвт төвлөрүүлэх үндсэн үйл ажиллагааны орлого болох зохицуулалтын үйлчилгээний хөлсийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс жил бүр орлогын төлөвлөгөөний батлагдсан дүнгээс давсан орлогыг авч зарцуулж байна. Тухайлбал: 2023 онд 150.8 сая төгрөг, 2024 онд 164.7 сая төгрөг болж өссөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 22 дугаар зүйлийн 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны бодит гүйцэтгэлд суурилж, үндэслэлтэй төлөвлөн, 2026 оны төсвийн саналыг бэлтгэх .

2. ХХААХҮЯ болон түүний харьяа газрууд Дархан-Уул аймгийн Дархан суманд шилжин суурьшсантай холбоотой зардлыг санхүүжүүлэх ажлын хүрээнд "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 02 дугаар тогтоол, ТУЗ-ийн 2024 оны 25 дугаар тогтоолын дагуу төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн төлбөрийг бууруулах шийдвэрийг гаргаж, ХХААХҮЯ-ны 45, ЖДҮГ-ын 7 албан хаагчид орон сууцны урьдчилгаа төлбөрт нийт 3,126.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Хувьцаа эзэмшигчийн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлж, компанийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй хөтөлбөр, арга хэмжээг компанийн зардлаас санхүүжүүлэхгүй байх.

**3.3 Түүврийн байгууллага** */ ХХААХҮЯ-ны Хөрөнгө оруулалт, Техник хяналтын зардал, Хөтөлбөр, арга хэмжээний зардал /*

**3.3.1 Төлбөрийн акт**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2019 онд хэрэгжиж дууссан 13 төсөл, арга хэмжээний 83.5 сая төгрөгийн чанарын баталгааны зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д " Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "

төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний чанарын баталгааны зарцуулагдаагүй үлдэгдэл 83.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтов.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2023 онд хэрэгжиж дууссан 3 төсөл арга хэмжээний 5.6 сая төгрөгийн техник хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д " Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д " төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.3.9-д "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан, ашиглалтад орсонтой холбогдуулан энэ журмын 4.3.8-д заасан зардлаас зарцуулагдаагүй үлдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний техник хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 5.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтов.

**3.3.2 Зөвлөмж**

**1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт:</u>*

ХХААХҮС-ын 2024 оны төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө төсөл хүрээнд хэрэгжиж байгаа зарим төсөл, арга хэмжээ нь төсвийн төслийн жагсаалтад тэргүүлэх ээлжид эрэмбэлэгдээгүй, салбарын бодлоготой бүрэн уялдаагүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын нэгдсэн судалгаа тооцоолол хийгдээгүйгээс тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд бүрэн шилжиж, эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэгдэх боломжгүй цаашид иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд ашиглагдах зориулалт бүхий хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ батлагдаж, санхүүжигдэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна", 30 дугаар зүйлийн 3-т "Хуульд өөрөөр заагаагүй

бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төсөл дэх төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлагад бүрэн нийцүүлэн төлөвлөж, саналыг хүргүүлэх.

**2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Бяслагийн үйлдвэрийн /Хөвсгөл, Жаргалант, Цагаан-Уул, Галт, Тосонцэнгэл, Рэнчинлхүмбэ, Цагаан-Үүр, Рашаант, Их-Уул сум/ 6,836.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 1,330.6 сая төгрөгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлт хангалтгүйгээс гэрээг цуцлах шийдвэрийг гаргаж, гүйцэтгэгч компанитай шүүхийн маргаан үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т " өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.2.6-д “Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, бүрэн хариуцах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлж, хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг хангаж ажиллах.

**3. Орлогын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

ХХААХҮС-ын 2024 оны А/257 дугаар тушаалаар хаврын тариалалтад зориулан улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 11 төрлийн төмс, хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үрийн үнийг 80.0 хувиар хөнгөлж, аймаг, нийслэлийн ХААГ-аар дамжуулан хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хуваарилсан байна. Дээрх арга хэмжээний хүрээнд борлуулсан үрийн үнийн дүнгийн 20 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхээс 148.4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3-т "төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны “Хөрөнгө шилжүүлэх, дэмжлэгийн нөхцөл тогтоож, хуваарь батлах тухай” А/257 дугаар тушаалын холбогдох заалттай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хуваарилсан төмс, хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үрийн үнийн 20 хувь болох 148.4 сая төгрөгийн авлагын бүрэн барагдуулж ажиллах.

**4. Зардлын данстай холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт:</u>*

Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.10.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөтөлбөр, арга хэмжээний зардалд жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг 4 аймагт байгуулахад 980.0 сая төгрөг, тариалангийн талбайг хашаажуулж ойн зурвас байгуулах ажилд 6,376.5 сая төгрөгийг урсгал зардлын ангилалд төлөвлөн, хэрэгжүүлсэн, мөн яамны үндсэн үйл ажиллагаатай холбоотой зарим урсгал зардлыг санхүүжүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.4-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах”, 31 дүгээр зүйлийн 31.4.6-д “төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо”, 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийн зардлыг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж байх.

**5. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт:</u>*

Хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гэрээнд зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн үүргийг хангуулах чанарын баталгааны хувь хэмжээг тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-т “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээнд үүргийг хангуулах чанарын баталгааны хувь хэмжээг тусгаж байх.

## 4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 10,082.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6,030.0 сая төгрөгийн

зөрчилд 17 албан шаардлага, 4,057.7 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ХХААХҮС болон түүний эрхлэх асуудлын хүрээний 1 төвлөрүүлэн захирагч, төсвийн 54 байгууллага, 1 ЗГТС, төрийн өмчит 4 хуулийн этгээд , хуулийн 3.1.4-т хамаарах улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй 4 төслийн байгууллага, нийт 65 байгууллага 3316 мэдээлэл байршуулахаас 3203 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, 79 мэдээллийн хугацааг хоцроож, 34 мэдээллийг байршуулаагүй, нийт мэдээллийн 96.6 хувийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 9,190.7 сая төгрөгийн 17 зөрчил илэрснээс 5,459.3 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 3,731.4 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгсөн байна.

1. ТЕЗ-ийн Шилэн дансны цахим хуудсанд эхний хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 3 мэдээллийг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны тайлангийн мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан холбогдох мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой 891.6 сая төгрөгийн 33 зөрчил илэрснээс 1.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 570.7 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 319.4 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмж, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгсөн байна.

***Төсвийн ерөнхийлөн захирагч***

1. ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагууд батлагдсан төсвийн дагуу тухайн жилийн төсөвт батлагдсан бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, тайлагнах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлээгүй, ТЕЗ-ийн зүгээс бүрэн хяналт, тавиагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан " Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1-д “Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу

санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна", 2.6.4-т "төсвийн ерөнхийлөн захирагч дээрх төсвийн захирагчдын төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хянаж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. ХХААХҮС-ын 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд Нэг маягийн зураг төсөлтэй болон ТАХ-ний жишиг магадлалтай 7 төсөл, арга хэмжээ батлагдаж, гүйцэтгэлээр 7,849.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан " Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байх.

*3.* ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн 163,527.6 сая төгрөг, нийцлийн аудитын асуудлаар 10,082.6 сая төгрөг, нийт 173,609.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн , мөн 12 байгууллага, төсвийн захирагчийн санхүүгийн тайланд Хязгаарлалттай, 2 байгууллагын санхүүгийн тайланд Сөрөг дүгнэлт өгөгдсөн байна. */ТЕЗ-ийн СНТ, УТХО,барьцаа, техник хяналт, Хөтөлбөр арга хэмжээний санхүүгийн тайланд хийсэн аудитын илрүүлэлт ороогүй дүн болно/*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудтай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/ сая төгрөгөөр/*

| д/д | Шалгагдагч байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| | I.Засгийн газрын тусгай сан | | | | | | | | | | | | |
| 1 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 2 | 21,933.15 | | | 2 | 21,933.1 | 2 | 21,933.1 | | | | |
| | Дүн | 2 | 21,933.15 | | | 2 | 21,933.1 | 2 | 21,933.1 | | | | |
| | II. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага | | | | | | | | | | | | |
| 2 | Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК | 7 | 107,293.0 | 4 | 11,688.5 | 3 | 95,604.5 | 7 | 107,293.0 | | | | |
| | Дүн | 7 | 107,292.98 | 4 | 11,688.5 | 3 | 95,604.5 | 7 | 107,293.0 | | | | |
| | III.Төсвийн шууд захирагч | | | | | | | | | | | | |
| 3 | Говь-Алтай амйгийн МЭГ | 1 | 350.9 | | | 1 | 350.9 | 1 | 350.9 | | | | |
| 4 | Говьсүмбэр аймгийн МЭГ | 4 | 4.7 | | | 4 | 4.7 | 2 | 4.7 | 2 | | 2 | |
| 5 | Дундговь аймгийн МЭГ | 3 | 205.6 | | | 3 | 205.6 | 3 | 205.6 | | | | |
| 6 | Завхан аймгийн МЭГ | 3 | 1,484.1 | | | 3 | 1,484.1 | 3 | 1,484.1 | | | | |
| 7 | Мал эмнэлгийн ариун цэврийн төв лабортори | 1 | 0.9 | | | 1 | 0.9 | 1 | 0.9 | | | | |
| 8 | Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ | 3 | 135.5 | 1 | 31.0 | 2 | 104.5 | 3 | 135.5 | | | | |
| 9 | Нийслэлийн МЭГ | 2 | 18.6 | | | 2 | 18.6 | 2 | 18.6 | | | | |
| 10 | Төв аймгийн МЭГ | 6 | 2,332.0 | | | 6 | 2,332.0 | 6 | 2,332.0 | | | | |
| 11 | Ховд аймгийн МЭГ | 2 | 163.7 | 1 | 83.5 | 1 | 80.2 | 2 | 163.7 | | | | |
| 12 | Хөвсгөл аймгийн МЭГ | 3 | 6,559.7 | | | 3 | 6,559.7 | 3 | 6,559.7 | | | | |
| 13 | Өмнөговь аймгийн МЭГ | 2 | 171.9 | | | 2 | 171.9 | 2 | 171.9 | | | | |
| 14 | Булган аймгийн ХХААГ | 2 | 3,893.0 | 2 | 3,893.0 | | | 1 | 3,881.2 | 1 | 11.8 | 1 | 11.8 |
| 15 | Баянхонгор аймгийн ХХААГ | 3 | 15.5 | 1 | 0.0 | 2 | 15.5 | 3 | 15.5 | | | | |
| 16 | Говь-Алтай аймгийн ХХААГ | 1 | 23.0 | | | 1 | 23.0 | 1 | 23.0 | | | | |
| 17 | Говьсүмбэр аймгийн ХХААГ | 1 | 29.9 | | | 1 | 29.9 | 1 | 29.9 | | | | |
| 18 | Дархан-Уул аймгийн ХХААГ | 3 | 16.7 | | | 3 | 16.7 | 3 | 16.7 | | | | |
| 19 | Орхон аймгийн ХХААГ | 1 | 2.6 | | | 1 | 2.6 | 1 | 2.6 | | | | |
| 20 | Сэлэнгэ аймгийн ХХААГ | 2 | 96.4 | 1 | 90.4 | 1 | 6.0 | 2 | 96.4 | | | | |
| 21 | Төв аймгийн ХХААГ | 6 | 843.1 | | | 6 | 843.1 | 6 | 843.1 | | | | |
| 22 | Ховд аймгийн ХХААГ | 1 | 107.4 | | | 1 | 107.4 | 1 | 107.4 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Хөвсгөл аймгийн ХХААГ | 1 | 7.9 | | | 1 | 7.9 | 1 | 7.9 | | | | |
| 24 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны аппарат | 4 | 1,673.3 | | | 4 | 1,673.3 | 4 | 1,673.3 | | | | |
| 25 | Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори | 1 | 0.9 | | | 1 | 0.9 | 1 | 0.9 | | | | |
| 26 | Малын удмын сангийн үндэсний төв | 2 | 212.0 | | | 2 | 212.0 | 2 | 212.0 | | | | |
| 27 | Жижиг, дунд үйлдвэрийн газар | 1 | 2.3 | | | 1 | 2.3 | | | 1 | 2.3 | 1 | 2.3 |
| | Дүн | 59 | 18,351.8 | 6 | 4,098.0 | 53 | 14,253.8 | 55 | 18,337.6 | 4 | 14.2 | 4 | 14.2 |
| | НИЙТ ДҮН | 68 | 147,577.9 | 10 | 15,786.5 | 58 | 131,791.4 | 64 | 147,563.8 | 4 | 14.2 | 4 | 14.2 |

## 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/сая төгрөгөөр/*

| № | Шалгагдагч байгууллагын нэр | Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | |
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Дүн | Тоо | Дүн |
| А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | I.Төсвийн ерөнхийлөн захирагч | | | | | | | | | | | | | |
| 1 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл. | 4 | 80,687.8 | | | 2 | 80,687.8 | 2 | | | | | | |
| | Дүн | 4 | 80,687.8 | | | 2 | 80,687.8 | 2 | | | | | | |
| | II.Засгийн газрын тусгай сан | | | | | | | | | | | | | |
| 2 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 6 | 30,835.5 | | | 4 | 30,835.5 | 2 | | | | | | |
| | Дүн | 6 | 30,835.5 | | | 4 | 30,835.5 | 2 | | | | | | |
| | III.Төсвийн төвлөрүүлэн захирагч | | | | | | | | | | | | | |
| 3 | Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ | 6 | 1,912.0 | | | 4 | 1,787.1 | 2 | 124.9 | | | | | |
| | Дүн | 6 | 1,912.0 | | | 4 | 1,787.1 | 2 | 124.9 | | | | | |
| | IV. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага | | | | | | | | | | | | | |
| 4 | Дарханы арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК | 5 | 60.1 | | | 4 | 60.1 | 1 | | | | | | |
| 5 | Хөдөө Аж Ахуйн Бирж ХХК | 3 | 3,616.7 | | | 2 | 3,150.0 | 1 | 466.7 | | | | | |
| 6 | Биокомбинат ТӨХХК | 3 | 79.2 | | | 1 | 16.5 | 2 | 62.7 | | | | | |
| 7 | Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК | 24 | 123,148.6 | | | 10 | 111,755.6 | 14 | 11,393.0 | | | | | |
| | Дүн | 35 | 126,904.6 | | | 17 | 114,982.2 | 18 | 11,922.4 | | | | | |
| | V.Төсвийн шууд захирагч | | | | | | | | | | | | | |
| 8 | Архангай аймгийн МЭГ | 2 | 2.6 | | | 2 | 2.6 | | | | | | | |
| 9 | Булган аймгийн МЭГ | 5 | 34.4 | 3 | 25.9 | | | 2 | 8.5 | | | | | |
| 10 | Баянхонгор аймгийн МЭГ | 3 | 8.6 | 1 | 1.4 | 2 | 7.2 | | | | | | | |
| 11 | Баянөлгий аймгийн МЭГ | 1 | 1.5 | | | 1 | 1.5 | | | | | | | |
| 12 | Говь-Алтай амйгийн МЭГ | 2 | 5.7 | 1 | 0.3 | | | 1 | 5.4 | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Говьсүмбэр аймгийн МЭГ | 2 | 2.3 | | | 2 | 2.3 | | | | | | | |
| 14 | Дархан-Уул аймгийн МЭГ | 1 | 2.2 | | | | | 1 | 2.2 | | | | | |
| 15 | Дорнод аймгийн МЭГ | 1 | 1.5 | 1 | 1.5 | | | | | | | | | |
| 16 | Дорноговь аймгийн МЭГ | 4 | 43.8 | | | | | 4 | 43.8 | | | | | |
| 17 | Дундговь аймгийн МЭГ | 2 | 5.0 | 1 | 2.0 | 1 | 3.0 | | | | | | | |
| 18 | Завхан аймгийн МЭГ | 1 | 0.4 | 1 | 0.4 | | | | | | | | | |
| 19 | Мал эмнэлгийн ариун цэврийн төв лабортори | 3 | 23.8 | 1 | 1.2 | 1 | 12.1 | 1 | 10.5 | | | | | |
| 20 | Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ | 3 | 246.4 | | | 1 | 178.9 | 2 | 67.5 | | | | | |
| 21 | Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори | 4 | 10.5 | | | | | 4 | 10.5 | | | | | |
| 22 | Нийслэлийн МЭГ | 2 | 0.7 | | | | | 2 | 0.7 | | | | | |
| 23 | Орхон аймгийн МЭГ | 7 | 12.5 | 1 | 2.6 | 2 | 3.9 | 4 | 6.0 | | | | | |
| 24 | Сэлэнгэ аймгийн МЭГ | 1 | 0.9 | | | | | 1 | 0.9 | | | | | |
| 25 | Сүхбаатар аймгийн МЭГ | 5 | 20.5 | 2 | 11.8 | 3 | 8.7 | | | | | | | |
| 26 | Төв аймгийн МЭГ | 6 | 1.3 | 3 | 0.8 | 1 | | 2 | 0.5 | | | | | |
| 27 | Увс аймгийн МЭГ | 1 | 1.1 | 1 | 1.1 | | | | | | | | | |
| 28 | Ховд аймгийн МЭГ | 3 | 22.9 | 1 | 3.1 | | | 2 | 19.8 | | | | | |
| 29 | Хөвсгөл аймгийн МЭГ | 2 | | | | | | 2 | | | | | | |
| 30 | Өвөрхангай аймгийн МЭГ | 1 | 10.0 | | | 1 | 10.0 | | | | | | | |
| 31 | Өмнөговь аймгийн МЭГ | 4 | 18.2 | 1 | 1.2 | 2 | 17.0 | 1 | | | | | | |
| 32 | Архангай аймгийн ХХААГ | 4 | 22.1 | | | 4 | 22.1 | | | | | | | |
| 33 | Булган аймгийн ХХААГ | 11 | 346.0 | 3 | 10.6 | 4 | 41.1 | 3 | 294.4 | 1 | | 1 | | |
| 34 | Баянхонгор аймгийн ХХААГ | 2 | 17.1 | | | 2 | 17.1 | | | | | | | |
| 35 | Баянөлгий аймгийн ХХААГ | 2 | 11.5 | | | 2 | 11.5 | | | | | | | |
| 36 | Говь-Алтай аймгийн ХХААГ | 4 | 10.1 | | | 3 | 10.1 | 1 | | | | | | |
| 37 | Говьсүмбэр аймгийн ХХААГ | 1 | 0.2 | | | | | 1 | 0.2 | | | | | |
| 38 | Дархан-Уул аймгийн ХХААГ | 1 | 2.2 | | | | | 1 | 2.2 | | | | | |
| 39 | Дорнод аймгийн ХХААГ | 2 | 8.7 | | | 2 | 8.7 | | | | | | | |
| 40 | Дорноговь аймгийн ХХААГ | 2 | | | | | | 2 | | | | | | |
| 41 | Дундговь аймгийн ХХААГ | 3 | 14.4 | | | 3 | 14.4 | | | | | | | |
| 42 | Завхан аймгийн ХХААГ | 4 | 13.2 | 1 | 0.7 | | | 3 | 12.5 | | | | | |
| 43 | Орхон аймгийн ХХААГ | 10 | 21.9 | 5 | 5.3 | 2 | 14.4 | 3 | 2.2 | | | | | |
| 44 | Сэлэнгэ аймгийн ХХААГ | 5 | 936.2 | 1 | 1.2 | 2 | 932.3 | 2 | 2.8 | | | | | |
| 45 | Төв аймгийн ХХААГ | 9 | 37.7 | 3 | 4.9 | 1 | | 5 | 32.8 | | | | | |
| 46 | Сүхбаатар аймгийн ХХААГ | 2 | 9.4 | | | 2 | 9.4 | | | | | | | |
| 47 | Ховд аймгийн ХХААГ | 4 | 275.5 | | | 1 | 25.8 | 3 | 249.7 | | | | | |
| 48 | Хөвсгөл аймгийн ХХААГ | 3 | | | | | | 3 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 49 | Өмнөговь аймгийн ХХААГ | 3 | 7.2 | | | 1 | 7.2 | 2 | | | | | | |
| 50 | Халх гол бүтээн байгуулалтын бүсийн захиргаа | 7 | 141.2 | 2 | 11.8 | 4 | 114.6 | 1 | 14.8 | | | | | |
| 51 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв | 4 | 146.5 | | | 3 | 146.5 | 1 | | | | | | |
| 52 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны аппарат | 6 | 229.9 | | | 4 | 210.4 | 2 | 19.5 | | | | | |
| 53 | Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа | 2 | 4.1 | | | | | 2 | 4.1 | | | | | |
| 54 | Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори | 3 | 23.8 | 1 | 1.2 | 1 | 12.1 | 1 | 10.5 | | | | | |
| 55 | Малын удмын сангийн үндэсний төв | 7 | 757.0 | 2 | 3.6 | 3 | 293.1 | 2 | 460.3 | | | | | |
| 56 | Жижиг, дунд үйлдвэрийн газар | 4 | 362.8 | | | 2 | 360.5 | 2 | 2.3 | | | | | |
| 57 | ХХААХҮЯ-Техник хяналтын зардал | 1 | 5.6 | 1 | 5.6 | | | | | | | | | |
| 58 | ХХААХҮЯ-Хөрөнгө оруулалт | 3 | 1,414.1 | 1 | 83.5 | | | 2 | 1,330.6 | | | | | |
| 59 | ХХААХҮЯ-ны төвлөрсөн арга хэмжээ | 3 | 7,504.9 | | | | | 3 | 7,504.9 | | | | | |
| | Дүн | 178 | 12,800.1 | 38 | 181.6 | 65 | 2,498.4 | 74 | 10120.0<br>4 | 1 | | 1 | | |
| | НИЙТ ДҮН | 229 | 253,140.0 | 38 | 181.6 | 92 | 230,791.0 | 98 | 22,167.3 | 1 | | 1 | | |

## 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ сая төгрөгөөр/

| № | Шалгагдагч байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Албан шаардлага /Хариуцлага тооцуулах/ | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хүний тоо | Тоо | Дүн |
| А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | | | | | | |
| | I.Төсвийн ерөнхийлөн захирагч | | | | | | | | | | | | | |
| 1 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл. | 1 | | | | | | 1 | | | | | | |
| | Дүн | 1 | | | | | | 1 | | | | | | |
| | II.Засгийн газрын тусгай сан | | | | | | | | | | | | | |
| 2 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 1 | 1,832.4 | | | | | 1 | 1,832.4 | | | | | |
| | Дүн | 1 | 1,832.4 | | | | | 1 | 1,832.4 | | | | | |
| | III.Төсвийн төвлөрүүлэн захирагч | | | | | | | | | | | | | |
| 3 | Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ | 1 | | | | | | 1 | | | | | | |
| | Дүн | 1 | | | | | | 1 | | | | | | |
| | IV. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага | | | | | | | | | | | | | |
| 4 | Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК | 1 | 4,805.2 | | | 1 | 4,805.2 | | | | | | | |
| | Дүн | 1 | 4,805.2 | | | 1 | 4,805.2 | | | | | | | |
| | V.Төсвийн шууд захирагч | | | | | | | | | | | | | |
| 5 | Дорнод аймгийн МЭГ | 1 | | | | | | 1 | | | | | | |
| 6 | Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ | 1 | 1,668.3 | | | | | 1 | 1,668.3 | | | | | |
| 7 | Нийслэлийн МЭГ | 1 | | | | 1 | | | | | | | | |
| 8 | Орхон аймгийн МЭГ | 1 | | | | | | 1 | | | | | | |
| 9 | Төв аймгийн МЭГ | 1 | 40.2 | | | 1 | 40.2 | | | | | | | |
| 10 | Архангай аймгийн ХХААГ | 1 | | | | 1 | | | | | | | | |
| 11 | Булган аймгийн ХХААГ | 1 | 52.5 | | | 1 | 52.5 | | | | | | | |
| 12 | Орхон аймгийн ХХААГ | 1 | | | | | | 1 | | | | | | |
| 13 | Төв аймгийн ХХААГ | 1 | | | | | | 1 | | | | | | |
| 14 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны аппарат | 1 | 561.5 | | | 1 | 561.5 | | | | | | | |
| 15 | Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа | 1 | 74.7 | | | | | 1 | 74.7 | | | | | |
| 16 | Малын удмын сангийн үндэсний төв | 1 | 156.0 | | | | | 1 | 156.0 | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Жижиг, дунд үйлдвэрийн газар | 1 | | | | | | 1 | | | | | | |
| | Дүн | 13 | 2,553.1 | | | 5 | 654.1 | 8 | 1,899.0 | | | | | |
| | НИЙТ ДҮН | 17 | 9,190.7 | | | 6 | 5,459.3 | 11 | 3,731.4 | | | | | |
| | **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | | | | | | |
| | I.Төсвийн ерөнхийлөн захирагч | | | | | | | | | | | | | |
| 1 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл. | 2 | | | | | | 2 | | | | | | |
| | Дүн | 2 | | | | | | 2 | | | | | | |
| | II.Засгийн газрын тусгай сан | | | | | | | | | | | | | |
| 2 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 1 | | | | | | 1 | | | | | | |
| | Дүн | 1 | | | | | | 1 | | | | | | |
| | III.Төсвийн төвлөрүүлэн захирагч | | | | | | | | | | | | | |
| 3 | Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ | 2 | | | | 1 | | 1 | | | | | | |
| | Дүн | 2 | | | | 1 | | 1 | | | | | | |
| | IV. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага | | | | | | | | | | | | | |
| 4 | Хөдөө Аж Ахуйн Бирж ХХК | 2 | 36.1 | | | 1 | 36.1 | 1 | | | | | | |
| 5 | Биокомбинат ТӨХХК | 1 | 201.1 | | | 1 | 201.1 | | | | | | | |
| 6 | Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК | 8 | 320.6 | | | 4 | 320.6 | 3 | | 1 | | 2 | | |
| | Дүн | 11 | 557.8 | | | 6 | 557.8 | 4 | | 1 | | 2 | | |
| | V.Төсвийн шууд захирагч | | | | | | | | | | | | | |
| 7 | Мал эмнэлгийн ариун цэврийн төв лабортори | 2 | 26.3 | | | | | 2 | 26.3 | | | | | |
| 8 | Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори | 1 | 21.5 | | | | | 1 | 21.5 | | | | | |
| 9 | Хөвсгөл аймгийн МЭГ | 1 | | | | | | 1 | | | | | | |
| 10 | Говь-Алтай аймгийн ХХААГ | 3 | 5.7 | | | 3 | 5.7 | | | | | | | |
| 11 | Говьсүмбэр аймгийн ХХААГ | 2 | 0.8 | | | | | 2 | 0.8 | | | | | |
| 12 | Дундговь аймгийн ХХААГ | 1 | 7.2 | | | 1 | 7.2 | | | | | | | |
| 13 | Хэнтий аймгийн ХХААГ | 1 | 1.5 | 1 | 1.5 | | | | | | | | | |
| 14 | Хөвсгөл аймгийн ХХААГ | 1 | | | | | | 1 | | | | | | |
| 15 | Халх гол бүтээн байгуулалтын бүсийн захиргаа | 1 | | | | | | 1 | | | | | | |
| 16 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны аппарат | 1 | 244.5 | | | | | 1 | 244.5 | | | | | |
| 17 | Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори | 2 | 26.3 | | | | | 2 | 26.3 | | | | | |
| 18 | ХХААХҮЯ-Хөрөнгө оруулалт | 1 | | | | | | 1 | | | | | | |
| | Дүн | 17 | 333.8 | 1 | 1.5 | 4 | 12.9 | 12 | 319.4 | | | | | |
| | Нийт дүн | 33 | 891.6 | 1 | 1.5 | 11 | 570.7 | 20 | 319.4 | 1 | | 2 | | |
| | НИЙТ ДҮН | 50 | 10,082.3 | 1 | 1.5 | 17 | 6,030.0 | 31 | 4,050.7 | 1 | | 2 | | |